

OKX



МОНГОЛ УЛСЫН
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 148

Улаанбаатар хот

Цэргийн бэлтгэл сургалт зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6, Цэргийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.10 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 376 дугаар тогтоолоор батлагдсан "Аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын удирдах бүрэлдэхүүнтэй сургалт, дадлага явуулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хэвлэл, мэдээллийн байгууллагын удирдах бүрэлдэхүүнтэй явуулах цэргийн бэлтгэл сургалтыг 2021 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Батлан хамгаалах яам, Хужирбулан дахь сургалтын төвийг түшиглэн зохион байгуулсугай.

2. Цэргийн бэлтгэл сургалтад оролцох бүрэлдэхүүний нэрийн жагсаалтыг нэгдүгээр, сургалтын хөтөлбөрийг хоёрдугаар, сургалтад ашиглах зэвсэг, зарцуулах галт хэрэглэлийн тооцоог гуравдугаар, шаардагдах зардлын тооцоог дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, хошууч генерал Д.Ганзоригт даалгах нь:

а. Сургалтад оролцох бүрэлдэхүүнтэй галын бэлтгэлийн хичээл явуулахад зориулж хавсралтад заагдсан хүн нэг бүрийн буудлагын зэвсгийг шаардагдах галт хэрэглэлийн хамт гаргах;


б. Буудлагын үеийн дадлага, сургалтыг явуулж, аюулгүйн ажиллагааны зааврыг чанд мөрдүүлэн буудлага хийлгэх;

в. Сургалтад оролцох бүрэлдэхүүнийг тээвэрлэх жолооч нар, автотехникүүд /Старекс маркийн автомашин 4 нэгж/-ийн бэлэн байдлыг хангаж, томилон ажиллуулах;

г. Зэвсэгт хүчний 084 дүгээр ангиас тусгай ажиллагааны үзүүлэх тоглолт хийлгэж, шинэ зэвсэг, техник, хувцас хэрэглэлийн үзэсгэлэн бэлтгэж үзүүлэх.

4. Цэргийн бэлтгэл сургалтын явцад урлаг, соёлын хэсэгчилсэн арга хэмжээ зохион байгуулахыг Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулга /хурандаа Г.Золзаяа/-д хариуцуулсугай.

2021.03.13




1321100086

5. Дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан 5,852,500.00 (таван сая найман зуун тавин хоёр мянга таван зуун) төгрөгийг хичээл, үйлдвэрлэлийн дадлага, сургуулилтын зардлаас гаргахыг яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /хурандаа Д.Ганбат/-т зөвшөөрсүгэй.

6. Цэргийн бэлтгэл сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, дүнг илтгэхийг яамны Төрийн нарийн бичгийн дарга /хурандаа Д.Ганхуяг/-д үүрэг болгосугай.

САЙД



Г.САЙХАНБАЯР

